



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/22

Хэрлэн сум

Аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг
итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Иргэний хуулийн 64 дүгээр зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 12, 13 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас зээл авч хугацаа хэтрүүлсэн иргэдийн зээлийн асуудлаар иргэний хэргийн анхан шатны шүүх, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Д.Цэцэгсүрэн)-ийг томилсугай.

2.Итгэмжлэгдсэн төлөөлөгч аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 12, 13 дугаар зүйлд заасан эрхийг эдлэх бүрэн эрхийг олгосугай.

3.Холбогдох баримт, бичгийг бүрдүүлж, хуульд заасан эрхийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Д.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ